



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 2/439

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.“а”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн төсөв батлах тухай” 13/08 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтанд батлагдсан 2020 онд аймгийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, жагсаалтын 6-д тусгагдсан “Од” хорооллын нийтийн орон сууцны халаалтын зуухны засварт зориулсан 50,000,000 (тавин сая) төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтанд тусгагдсан засварын зардлуудыг батлагдсан төсвөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр), засварын ажилд хяналт тавьж, хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-д тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011101082

Аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 114/29 дугаар захирамжийн хавсралт

ОД" ХОРООЛЛЫН НИЙТИЙН ОРОН СУУЦНЫ ХАЛААЛТЫН ЗУУХНЫ
ЗАСВАРТ ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

| № | Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр | Төсөвт өртөг /мян төг/ |
|---|---|---------------------------|
| 1 | Халаалтын тогоо худалдан авах /HP100Ж/ | 29000.0 |
| 2 | Халаалтын тогоо угсрах, тээвэр, кран, туслах материал | 5720.0 |
| 3 | Сүлжээний насос /45кВт/ | 6000.0 |
| 4 | Халаалтын тогооны барилга угсралт | 6000.0 |
| 5 | Дулааны шугам сүлжээнд тавих шаб болон тохируулгын ажил | 3280,0 |
| | НИЙТ ДҮН | 50000.0 |

-оОо-